

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД
НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ**

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
1.1	Эцэг/эхийн нэр: Намжилдорж Нэр: Энхбаяр. . . .
1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. <i>Монгол улсын иргэн</i>
1.4	Хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа эсэх: -эдийн засаг, санхүүгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх; <i>Эдийн засгийн ухааны бакалавр, Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй</i> -сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн үйл ажиллагаа явуулаагүй байх; <i>. . 1992 оноос хойш тасралтгүй төрийн албанд ажиллаж ирсэн, Төрийн захиргааны албан хаагч, Төрийн албаны дөтгөөр зэргийн тэргүүн түшмэл зэрэгтэй</i> -зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй байх; <i>. . . аливаа банк болон ББСБ-д хугацаа хэтэрсэн зээлийн өргүй, одоо ашиглаж буй зээлийн үлдэгдэл байхгүй</i> -хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх; Тийм - эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн байх, эсхүл эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх.

	<p>Ажиллаж ирсэн түүх:</p> <ul style="list-style-type: none"> • 1992-2000 онуудад Сангийн яамны Төсвийн бодлогын газарт мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, • 2001-2004 онуудад Сангийн яамны Төсвийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, газрын орлогч дарга, • 2005-2007 онуудад Сангийн яамны Салбарын бодлого, хөрөнгө оруулалтын газрын дарга, Макро эдийн засгийн газрын дарга, • 2004-2006 онуудад Үнэт цаасны Хорооны орон тооны бус гишүүн, • 2006 оны 11-р сараас 2011 оны 3-р сарыг хүртэл Монгол Улсын Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын зөвлөх, • 2011 оны 3-р сараас 2015 оныг хүртэл Дэлхийн банкны Австрали, Өмнөд Солонгос, Монгол Улсыг хариуцсан гүйцэтгэх захирлын зөвлөх, • 2015 оны 9 дүгээр сараас 2016 оны 10-р сарыг хүртэл Монгол Улсын Засгийн газрын Эдийн засгийн үндэсний хорооны шинжээч, мөн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн даргын зөвлөх, • 2017-2018 онуудад Монголбанкны Мөнгөний Бодлогын хорооны гишүүн, • 2016 оны 10 дугаар сараас 2019 оны 7 дугаар сарыг хүртэл Монгол Улсын Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлогын зөвлөхөөр ажилласан. • 2019 оны 8 дугаар сараас 2020 оны 4-р сарыг хүртэл бие даасан эдийн засгийн судлаач, • 2020 оны 4 сараас 2021 оны 10-р сарыг хүртэл Удирдлагын Академийн Бодлого судлалын тэнхмийн багш, • Удирдлагын Академийн Захирал доктор Д.Сүрэнчимэг, утас 99094767 • Захиргаа хүний нөөцийн ажилтан Б.Урангоо 70131754 • 2021 оны 10-р сараас хойш өнөөг хүртэл Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн дэргэдэх Стратеги судалгааны хүрээлэнгийн Эдийн засгийн Аюулгүй байдлын судалгааны төвд ахлах судлаачаар ажиллаж байна. Стратеги судалгааны хүрээлэнгийн захирал Б.Даваадорж 99095334 • Захирлын туслах Баасанхүү 264000
1.5	<p>Мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар Хүсэлт гарагчийг эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр өндөр мэдлэг, ур чадвартайг нотлох онцлох 10 үйл ажиллагааг жагсаан (хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар) бичнэ. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <p>Нэг. Монгол Улсын Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлогын зөвлөхөөр 2006-2011 болон 2016-2019 онуудад ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> - “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн Үзэл баримтлал 2030”-ыг боловсруулах ажлын хэсэгт багтаж тодорхой бүлэг, заалтууд, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахад оролцсон,

- Монгол Улсын Ерөнхий сайдын УИХ-ын чуулганд хийж ирсэн олон талын мэдээллийг боловсруулж, бэлтгэсэн,
- Холбоо барих байгууллага: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Хоёр. Сангийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргаар 2005-2006 онуудад ажилласан.

- Жил бүрийн улсын төсвийн төсөл боловсруулахад шаардагдах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцооллыг хариуцан хийж ирсэн,
 - Мянганы хөгжлийн цогц бодлого баримт бичгийг боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, Цогц бодлогыг боловсруулан Монгол улсын Ерөнхийлөгчид уламжилсан,
- Холбоо барих байгууллага: Сангийн яам

Гурав. Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлогын газарт 10 жил ажилласан, үүний дотор газрын орлогч даргаар 2003-2004 онуудад ажилласан.

- Монгол улсын Төсвийн тухай 1993 оны хууль, Төсвийн байгууллага удирдлага санхүүжилийн тухай хуулийг боловсруулах ажлын хэсэгт оролцож ажилласан,
- Жил бүрийн Төсвийн хуулийн төсвийн орлогын хэсгийн тооцоолол, нэгтгэлийг боловсруулах явцад ажилласан,
- Холбоо барих байгууллага: Сангийн яам

Дөрөв. Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр 2017-2018 онуудад ажилласан,

- Мөнгөний бодлогын хорооны шийдвэр гаргах явцад санал, дүгнэлтээ гаргаж, танилцуулж оролцож ирсэн.
- Холбоо барих байгууллага: Монголбанкны Тамгын газар

Тав. Үнэт цаасны хорооны гишүүнээр 2006-2008 онуудад ажилласан,

- ҮЦХ-ны гишүүнээр ажиллах явцадаа Санхүүгийн Зохицуулах Хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан,
- Холбоо барих газар: Санхүүгийн Зохицуулах Хороо

Зургаа. Вашингтон ДС хотод Дэлхийн Банкны гүйцэтгэх захирлын зөвлөхөөр 2011-2014 онуудад ажилласан.

- Дэлхийн Банкны Захирлуудын Зөвлөлийн хурлаар Монгол улсад хэрэгжүүлэх хэд хэдэн төслийг хэлэлцүүлэх, бэлтгэл ажлыг хангахад оролцсон,
- Дэлхийн банкны захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн нэг чухал төсөл нь Оюу -Толгой төсөлтэй холбогдох ОУСК-аас олгох хөнгөлөлттэй зээлийн асуудлыг хэлэлцүүлэхэд оролцсон,

Долоо. Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн дэргэдэх Стратеги Судалгааны Хүрээлэнгийн Эдийн засгийн аюулгүй байдлын судалгааны төвийн дарга, ахлах судлаачаар 2021 оноос хойш ажиллаж байна.

- Монгол улсын газрын ховор элементийн орд газрууд, нөөцийг цаашид ашиглах боломж, нөхцөлийн талаарх судалгаа,

	<ul style="list-style-type: none"> - Говийн бүсийн дэд бүтцийн төслүүдийн хэрэгжилтийн талаарх судалгаа, - Хөрш орнуудын геополитик, гео эдийн засаг болон эрчим хүчний салбарын талаарх судалгаа, - Монгол улсын Эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулах зэрэг судалгааг гүйцэтгэсэн. <p>Найм. Блүүмберг ТВ-ээс шалгаруулсан “2023 оны Шилдэг эдийн засагч” шагналыг хүртсэн,</p> <ul style="list-style-type: none"> - Монгол улсын эдийн засгийн хөгжил, эдийн засгийн бодлого, төсөв мөнгөний бодлого, дэлхийн эдийн засгийн төлөв байдлын талаар тогтмол хараат бус, бодит мэдээлэл түгээж байсныг ийнхүү үнэлсэн, <p>Ес. Төсвийн бодлого, төсвийн төсөлтэй холбогдсон асуудлуудаар иргэд олон нийтэд мэдээлэл түгээх, тайлбарлах үйл ажиллагааг 2001-2011, мөн 2018 оноос хойш тасралтгүй хийж ирсэн,</p> <ul style="list-style-type: none"> - Хэвлэл мэдээллийн байгууллагуудад тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төслийн талаар тайлбарлан яриа өгч, иргэд олон нийтэд төсвийн талаарх ойлголтыг олгож ирсэн, - Нээлттэй Нийгэм хүрээлэнгийн үйл ажиллагаанд тогтмол оролцож эдийн засаг, төсвийн асуудлаар мэдээ мэдээлэл бэлтгэх, хэлэлцүүлэг зохион байгуулахад оролцож ирсэн, <p>Арав. Удирдлагын Академийн Бодлого судлалын тэнхимд багшаар ажиллаж төрийн албан хаагчдад, мөн МУИС-ын Эдийн Засаг, бизнесийн сургуульд “Монголын Эдийн засгийн түүх” сэдвээр хичээл зааж, оюутан залуучууд, ирээдүйн боловсон хүчнийг бэлтгэхэд хувь нэмэр оруулж ирсэн.</p> <p>Холбоо барих байгууллага: Удирдлагын Академи, МУИС-ын Эдийн засаг Бизнесийн Сургууль.</p>
1.6	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p><i>Нээлттэй нийгэм хүрээлэнгийн Эдийн засагчдын клубын гишүүн, 2021 оноос хойш өнөөг хүртэл гишүүнээр ажиллаж, аливаа судалгаа, төслийг хэлэлцүүлэх, боловсруулах үйл ажиллагаанд оролцож ирсэн.</i></p>
1.7	<p>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</p> <p>Эрдэм шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн бүтээлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • “Төрийн удирдлага” сэтгүүлийн 2021 оны 11 дугаарт “Төрийн бодлогын шийдвэр гаргахад эдийн засгийн математик загварт тулгуурласан тооцооллын үр дүнг ашиглах нь” өгүүлэл нийтлүүлсэн. • “Стратегийн Судалгаа” сэтгүүлийн 2022 оны 83/2022 дугаарт “Дэлхийн эдийн засгийн төлөв: Геополитикийн нөхцөл байдал, Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл” өгүүлэл нийтлүүлсэн. • “Стратегийн Судалгаа” сэтгүүлийн 2022 оны 88/2022 дугаарт “Дэлхийн эдийн засаг худалдаа, геополитикт гарч буй өөрчлөлтүүд:

Монгол улсад үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөлөл” өгүүлэл нийтлүүлсэн.

- Стратеги Судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргадаг сар тутмын тойм 2023 оны 11-р сарын дугаарт “Дэлхийн геополитик, геозэдийн засагт гарч буй өөрчлөлт” сэдэвт өгүүлэл нийтлүүлсэн.
- Монголбанкнаас эрхлэн гаргадаг “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүлийн 2022 оны 31 дугаарт “Монгол Улс -Японы хоорондын улсын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг илүү үр дүнтэй ашиглах зарим боломж” сэдэвт өгүүлэл нийтлүүлсэн.
- “Эрсдэлд суурилсан Тогтвортой хөгжил” Эрдэм шинжилгээний хуралд “Монгол улсад урьдчилан сэрэмжлүүлэх, урьдчилан арга хэмжээ авах тогтолцоог хөгжүүлэх зарим асуудлууд” сэдвээр илтгэл тавьж оролцсон, илтгэлээ Дотоод Хэргийн Их Сургуулиас 2023 оны 10-р сард хэвлэн гаргасан хурлын товхимолд хэвлүүлсэн.

Ажлын хэсгийн хамт боловсруулан хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгүүд:

- “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн Үзэл баримтлал 2030”-ыг боловсруулах ажлын хэсэгт багтаж тодорхой бүлэг, заалтууд, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахад оролцсон.
- Мянганы хөгжлийн цогц бодлого баримт бичгийг боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, Цогц бодлогыг боловсруулсан.
- Монгол Улсын Засгийн газрын 2008-2012, 2016-2020 онуудын Үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах үйл ажиллагаанд оролцож эдийн засаг, төсөв, мөнгөний бодлогын талаарх бүлэг, шаардагдах хөрөнгө зардлын тооцооллыг боловсруулахад оролцсон. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хариуцан боловсруулсан.
- Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төсвийн тухай хуульд оруулсан удаа дараагийн нэмэлт өөрчлөлт, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн төслийг боловсруулж хэлэлцүүлэхэд оролцсон. Эдгээр хуулийн төслийг Сангийн яам, Санхүү, эдийн засгийн яамнаас боловсруулсан.

Хэвлэл мэдээлэлд өгсөн ярилцлага, нийтлэлүүдээс:

- Н.Энхбаяр: “Төсөв, мөнгөний бодлого хэвийн ажилласан ч “машин”-ыг бүрэн хөдөлгөж чадахгүй”, Зууны мэдээ сонин. 2016 оны 8-р сарын 23-ны өдөр.

Эх сурвалж: <https://ikon.mn/n/taj>

- Засгийн Газрын мэдээ сонины 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 187 дугаарт “Бүтцийн өөрчлөлт хийхгүй бол өнөөдрийн нөхцөл байдлаас салахгүй” ярилцлага;
- “Валютын урсгалыг нэн даруй нэмэгдүүлэх шаардлагатай байна”, UB info; 2016 оны 8-р сарын 12-ны өдөр

	<ul style="list-style-type: none"> • “Mongolian Economy” сэтгүүл, 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн дугаарт “Төсвийн зардлыг 1.2 их наяд төгрөгөөр хэмнэж байж алдагдалгүй байна” ярилцлага; Өдрийн сонины 2021 оны 1-р сарын 02-ны 231 дугаарт “Ковидын дараах эдийн засгийн сэргэлт ирэх намраас эхэлнэ” ярилцлага; <ul style="list-style-type: none"> • N.Enkhbayar: Improving Mongolia’s technical expertise is the key to its development • Mongolian Mining Journal, November 01, 2021, Source: https://www.mongolianminingjournal.com/a/71826 • Үндэсний Шуудан сонин, 2021 оны 148 дугаарт “Монгол Улс хөгжлийн бодлогоо орхигдуулсаар байх уу” нийтлэл. • Өдрийн сонины 2021 оны 7-р сарын 19-ний 135 дугаарт “Засгийн газар ухаалаг ажиллаж чадвал бид ирэх хавар маскаа тайлна” ярилцлага • “Эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай”, Mongolian Economy сэтгүүл, 2021 оны 11-р сарын 1-ний өдөр; Эх сурвалж: www.mongolianeconomy.mn/н-энхбаяр-монголд-тендерийн-процесс-х/ • Өдрийн сонины 2022 оны 07-р сарын 28-ны 138 дугаарт “Нүүрсний биет хэмжээ энэ хэвээр байвал оны эцэст 20 сая тоннд хүрнэ” ярилцлага; • Өдрийн сонины 2023 оны 10-р сарын 17-ны өдрийн 195 дугаарт “Геополитикийн ямар нэг асуудал үүсчихгүй бол зэсийн үнэ өндөр байх боломжтой” ярилцлага; эх сурвалж: https://dnn.mn/news/273551 • Өнөөдөр сонины 2023 оны 10-р сарын 5-ны өдрийн 195 дугаарт “Төсвийн зарлагыг ихээхэн өсгөхөөр төлөвлөсөн нь эрсдэл ихтэй байна” ярилцлага; Эх сурвалж: https://www.unuudur.mn/a/260597 • UB Post newspaper. 2023 оны 10-р сарын 18-ны өдрийн 116 дугаарт “Enkhbayar: Planned increase in budget expenditures can be risky”;
1.8	<p>Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/</p>
	Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй
1.9	<p>Сахилгын шийтгэлийн талаар Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх <i>Сахилгын шийтгэл хүлээж байгаагүй.</i></p>

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p>Төсвийн Зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлэх болсон үндэслэлийн тухайд:</p>
-----	--

Монгол улсын эдийн засаг өрөөсгөл бүтэцтэй, түүхий эдээс хамаарч эдийн засгийн өсөлт ихээхэн савладаг онцлогтой. Далайд гарцгүй орны хувьд гадаад онуудтай хийх худалдааны хувьд сонголт бага, дэд бүтцийн хөгжлийн өнөөгийн түвшнээс хамаарч уул уурхайн түүхий эдийг үндсэндээ нэг л зах зээлд борлуулж байгаа нь Монгол улсын төсвийн орлогын ихээхэн хэлбэлзэлтэй байх, богино хугацаанд өсөх ба мөн буурах эрсдэлд оруулдаг.

Ийм онцлог бүхий, түүхий эд экспорлогч орны хувьд төсвийн бодлого аж үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжсөн орнуудаас тодорхой ялгаатай буюу төсвийн орон зайтай байх шаардлагатай гэж эрдэмтэн судлаачид үздэг.

Өнгөрсөн жилүүдэд Монгол улсын 1997-98 оны Азийн хямрал, 2008-2009 оны дэлхийн эдийн засгийн хямрал, 2013-2016 онуудын түүхий эдийн үнийн бууралт, 2020-2022 оны ковидын цар тахлын үе зэрэг хүндрэлтэй цаг үеийг туулан гарч ирсэн. Энэ явцад Монгол улсын эдийн засаг, бизнес, нийгэм, хүний хөгжил, байгаль орчинд ихээхэн хохирол алдагдал учирсаар ирсэн.

Хөгжиж буй олон улс орны бодитой жишээ, ажилттай хөгжиж өндө рхөгжил хүрсэн болон буруу замаар, буруу бодлооготой явж дампуурал хямралд хүрсэн улс орнуудын бодит жишээнээс бид сургамж авч төсөв, мөнгөний болон Монгол улсын хөгжлийн бодлогод шинжлэх ухааны үндэслэлтэй, алсын хараатай хандах шаардлагатай.

Монгол улсын төсвийн төсөл гэдэг бол зөвхөн хэдэн арифметик тооны нийлбэр бус, орлого зарлагын тэнцэл бус, төсвийн төсөл бол Монгол улсын хөгжлийн бодлогын үргэлжлэл юм.

Ийм ч учраас Монгол улс цаашид тавьж буй урт, дунд хугацааны болон жилийн төлөвлөсөн зорилтондоо хүрэх эсэхэд төсвийн бодлого шийдвэрлэх үүрэгтэй, мөн макро эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангах нэг чухал хөшүүрэг бол төсвийн бодлого юм.

Олон улсын сайн туршлагад үндэслэн бий болгосон Төсвийн Зөвлөл төсвийн бодлогыг зөв зүйтэй хэрэгжүүлэхэд , бодлогын уялдааг хангахад чухал үүрэгтэй учраас Төсвийн Зөвлөлд нэрээ дэвшүүлж байна. Миний өнгөрсөн 30 жилд Төрийн алба, Олон улсын байгууллагад ажиллаж хуримтлуулсан туршлага, олж авсан онолын мэдлэг энэ бүхнийг амжилттай хэрэгжүүлэхэд тус болно гэж итгэж байна.

Хэрэв би Төсвийн зөвлөлийн гишүүнээр томилогдсон нөхцөлд эн тэргүүнд хийж гүйцэтгэх ажлын тухайд дурьдвал:

1. Төсвийн ил тод байдлыг хангах, иргэд олон нийтэд үнэ бодитой мэдээлэл өгөх зорилгоор төсвийн бодлого, төсвийн тухай хууль тогтоомж, төсвийн төслийн талаар олон нийт, эрдэмтэн судлаачид, бизнес эрхлэгчид зэрэг нийгмийн бүлгүүдийн дунд яриа таниулга хийх, хэлэлцүүлэг өрнүүлэх ажлыг тогтмол зохион байгуулна.

2. Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу аливаа бодлого шийдвэрийн төслийг боловсруулах явцад их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдыг өргөнөөр татан оролцуулж, тэдний дунд шинжлэх ухааны, ажил хэрэгч

<p>хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулна.</p> <p>3. Зөвхөн дотоодын судалгааны байгууллагаас гадна Олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, гадаад орны судалгааны байгууллагуудтай хамтран ажиллаж Монгол Улсын төсвийн тогтвортой байдлыг хангах, болзошгүй эдийн засгийн хямрал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарч ажиллана.</p> <p>4. Төсвийн тухай хуулийн 32.2.1-д заасны дагуу Монгол улсын макро эдийн засгийн нөхцөл байдлын үнэлгээ, цаашдын ирээдүйн чиг хандлагын талаарх төсөөлөл, тооцооллыг үндэслэл сайтай боловсруулж УИХ-ын холбогдох Байнгын хороонд уламжилж ажиллана.</p>

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: . Намжилдорж

Өөрийн нэр: . . . Энхбаяр

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2023 оны 12-р сарын 06-ны өдөр